



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**
Гүйцэтгэлийн аудитын алба



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын
төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт,
гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах”-д
хийсэн аудитын тайлан**

АУДИТЫН КОД: ДОА-2020/02/-ГА

Чойбалсан хот 2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер В.Цэнгэлмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Дэлгэрмаа
Утас: 7058-4207, Цахим хаяг: delgermaab@audit.gov.mn
Ахлах аудитор Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn
Аудитор Я.Зориг
Утас: 7058-4207, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn
Аудитор С.Энхбаатар
Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatarsu@audit.gov.mn
Аудитор Ж.Баяртуул
Утас: 7058-4207, Цахим хаяг: bayartuulj @audit.gov.mn
Гэрээт аудитор З.Шинэхүү
Утас: 7058-4207, Цахим хаяг: shinekhuuz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
БҮЛЭГ 1. УИХ-ЫН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА	
1.1. Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна.....	6
1.2. Сонгуулийн хороодод төсвийг аргачлалын дагуу хуваарилсан байна.....	7
БҮЛЭГ 2. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ АРВИЛАН ХЭМНЭЛТГҮЙ ЗАРЦУУЛСАН АСУУДАЛ ГАРСАН БАЙНА.	
2.1. Батлагдсан төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан асуудал гарсан байна.....	7
2.2. Аймаг, сумдын Сонгуулийн хороо төсвийн гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.....	8
2.3. Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.....	9
2.4. Аймгийн Сонгуулийн хороо хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хэрэгжүүлсэн байна.....	9
Холбогдох байгууллагын санал:	10
Саналд өгсөн тайлбар:	
ДҮГНЭЛТ:	10
ЗӨВЛӨМЖ:	11
ТУШААЛ:	12



Товчилсон үгийн тайлбар

ГА	Гүйцэтгэлийн аудит
ДОА	Дорнод аймаг
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
СЕХ	Сонгуулийн Ерөнхий хороо
СХ	Сонгуулийн хороо
ОБЕГ	Онцгой байдлын Ерөнхий газар
ОБГ	Онцгой байдлын газар



Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	“Аймгийн Сонгуулийн хорооны сонгуулийн нэгдсэн төсвийг 2016 оны сонгуулийн төсөвтэй харьцуулсан үзүүлэлт”	6
Хүснэгт 2	“Аймгийн Сонгуулийн хорооны сонгуулийн нэгдсэн зардлын задаргаа”	8

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	“Сонгуулийн хороодын төсвийн хуваарилалт 2016, 2020 он”	7



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 04 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/53 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл”-д аудит хийлээ.
Аудитын зорилт	Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: ■ УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх, ■ УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Дорнод аймагт Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн мэдээ, аймгийн болон 14 сумдын Сонгуулийн хороо, Онцгой байдлын газрын санхүүгийн баримт, материалыг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Гүйцэтгэлийн аудит MNS 6817-7:2020, Гүйцэтгэлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимуудыг ашиглав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер В.Цэнгэлмаа хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Б.Дэлгэрмаа, санхүүгийн аудитын албаны ахлах аудитор Д.Нармандах, аудитор Я.Зориг, С.Энхбаатар, Ж.Баяртуул, гэрээт аудитор З.Шинэхүү нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ. Аудитын талбарын ажлыг 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс эхлүүлж, тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ЯАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар болон аймгийн Сонгуулийн хорооны даргад 2020 оны 08 дугаар сарын 19-ний өдөр хүргүүлээ.



БҮЛЭГ1. УИХ-ЫН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

1.1 Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна.

Дорнод аймагт Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах аймгийн Сонгуулийн хорооны үйл ажиллагааны зардлын санхүүжилтэд Сонгуулийн ерөнхий хорооноос 393,405,400 төгрөгийн төсөв баталсан байна.

Сонгуулийн Ерөнхий хорооноос дээрх төсвийг аймгийн Сонгуулийн хороонд бүрэн хуваарилсан байна.

Аймгийн Сонгуулийн хорооны 2020 оны төсвийг 2016 оны сонгуулийн төсөвтэй харьцуулж хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1
/мян. төг/

д/д	Зардлын нэр төрөл	Төсөв		Зөрүү
		Батлагдсан 2016 он	Батлагдсан 2020 он	
1	Саналын хуудас устгах зардал	1,000.0	1,000.0	-
2	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	250.0	250.0	-
3	Сургалтын зардал	30,413.6	14,042.0	-16,371.6
4	Бичиг хэргийн зардал	17,600.0	11,680.0	-5,920.0
5	Шуудан холбооны зардал	18,100.0	13,900.0	-4200.0
6	Унааны зардал	37,000.0	42,650.0	5650.0
7	Хууль тогтоомж сурталчлах зардал	8,000.0	5,000.0	-3000.0
8	Санал авах байр бэлтгэх зардал	14,000.0	15,840.0	1,840.0
9	Саналын хуудас хүргэх	4,432.0	0,0	-4432,0
10	ICP машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх	11,900.0	14,910.0	3,010.0
11	МТБ-ийн мэдээ дамжуулах зардал	600.0	650.0	50.0
12	Томилолтын зардал	5,389.8	6,378.4	988.6
13	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх	3,430.0	2,520.0	-910.0
14	Сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	112,213.2	226,680.0	114,466.8
15	Сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал, /МТ/	23,801.6	32,650.0	8,848.4
16	Болзошгүй зардал	3,000.0	3,000.0	-
17	Бичиг хэргийн ажилтан, нягтлан бодогч нарын урамшуулал, хоолны зардал	1,700,0		-1700.0
18	Төрөл бүрийн үнэмлэх хэвлүүлэх	600.0		-600.0
19	Мэдээ дамжуулах унааны зардал		2,255.0	2,255.0
ДҮН		293,430.2	393,405.4	99,975.2

Дээрх хүснэгтээс харахад 2016 оноос сонгуулийн хорооны зардлыг нийт дүнгээр 99.9 сая төгрөгөөр өсгөж төлөвлөсөн байна.




Үүнд сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардлыг 123.3 сая төгрөгөөр, унааны зардал, санал авах байр бэлтгэх зардал, ИРС машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх зардал, томилолтын зардал, МТБ мэдээ дамжуулах зардлыг 50.0-5650.0 мянган төгрөгөөр өсгөсөн нь нөлөөлсөн байна. Өмнөх 2016 оны сонгуулийн зардлаас төрөл бүрийн үнэмлэх хэвлүүлэх зардал хасагдаж, бичиг хэргийн ажилтан, нягтлан бодогч нарын урамшуулал, хоолны зардал нь сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал дээр нэмэгдэж батлагдсан байна.

1.2 Сонгуулийн хороодод төсвийг аргачлалын дагуу тооцон хуваарилсан байна.

Сонгуулийн Ерөнхий хорооны ажлын албаны 2020 оны 3/101, 3/216, 3/281 тоот албан бичгээр ирүүлсэн аргачлал, зөвлөмжийн дагуу аймгийн Сонгуулийн хороо улсаас олгосон төсвийг сумдад хуваарилан ажилласан байна.

Дүрслэл 1. “Сонгуулийн хороодын төсвийн хуваарилалт 2016, 2020 он (сая.төг)”



Дээрх хүснэгтээс харахад сумдын сонгуулийн хороодод 2016 оноос нийт 30.4 хувиар төсвийг нэмэгдүүлж баталсан байна.

БҮЛЭГ 2. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ АРВИЛАН ХЭМНЭЛТГҮЙ ЗАРЦУУЛСАН АСУУДАЛ ГАРСАН БАЙНА.

2.1 Батлагдсан төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан асуудал гарсан байна.

Улсын Их Хурлын 2020 оны сонгуулийн зардалд улсын төсвөөс хуваарилсан 393,405,400 төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, зарцуулсан байна.

Сонгуулийн хороодын зардлын зарцуулалтыг төсвийн гүйцэтгэлийн мэдээ, дансны хуулга, анхан шатны баримтуудтай тулган шалгахад анхан шатны баримтгүй, баталсан төсвийг ангилал хооронд гүйлгэсэн зөрчил илрээгүй.



Харин ОБЕГ-аас нийлүүлсэн коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэхэд шаардагдах хамгаалах хэрэгсэл болон ариутгалын бодисоос үлдэгдэл болох 100 ш буюу 2.5 сая төгрөгийн 1 литрийн санитолыг ОБЕГ-т буцаасан байтал аймгийн Сонгуулийн хороо болзошгүй зардлаас 72 ширхэг буюу 734.4 мянган төгрөгийн гар ариутгагч худалдан авч арвилан хэмнэлтгүй зардлыг гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Аймаг, сумдын Сонгуулийн хороо төсвийн гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.

Аймгийн Сонгуулийн хороо төсвийн гүйцэтгэлийн мэдээг сумдын сонгуулийн хороодоос авч хянан нэгтгэж үнэн зөв тайлагнасан байна.

Аймгийн Сонгуулийн хорооны сонгуулийн нэгдсэн зардлын задаргааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2
/мян. төг/

д/д	Зардлын нэр төрөл	Төсөв		
		Батлагдсан 2016 он	Зарцуулсан 2020 он	Зөрүү
1	Саналын хуудас устгах зардал	1,000.0	1,000.0	0.0
2	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	250.0	250.0	0.0
3	Сургалтын зардал	14,042.0	14,042.0	0.0
4	Бичиг хэргийн зардал	11,680.0	11,680.0	0.0
5	Шуудан холбооны зардал	13,900.0	13,900.0	0.0
6	Унааны зардал	42,650.0	42,650.0	0.0
7	Хууль тогтоомж сурталчлах зардал	5,000.0	5,000.0	0.0
8	Санал авах байр бэлтгэх зардал	15,840.0	15,840.0	0.0
9	Саналын хуудас хүргэх	0,0	0,0	0.0
10	ICP машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх	14,910.0	14,910.0	0.0
11	МТБ-ийн мэдээ дамжуулах зардал	650.0	650.0	0.0
12	Томилолтын зардал	6,378.4	6,378.4	0.0
13	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх	2,520.0	2,520.0	0.0
14	Сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	226,680.0	226,680.0	0.0
15	Сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал, /МТ/	32,650.0	32,650.0	0.0
16	Мэдээ дамжуулах унааны зардал	2,255.0	2,255.0	0.0
ДҮН		393,405.4	393,405.4	0.0



2.3. Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 199 дүгээр тогтоолоор Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газрын нөөц сангаас хөрөнгө гаргахаар баталсан байна.

Манай аймагт сонгууль зохион байгуулахтай холбоотой Онцгой байдлын ерөнхий газраас аймгийн Онцгой байдлын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд сонгуулийн хороодод нэмэлтээр ажиллах 216 албан хаагчдын хоолны зардалд 2,592,000.0 төгрөгийг хуваарилсныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Мөн коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэхэд шаардагдах хамгаалах хэрэгсэл болон ариутгалын бодисыг ОБЕГ-аас аймгийн ОБГ-т нийлүүлсэн байна.

Аймгийн ОБГ аймгийн болон сумдын сонгуулийн хороодод хуваарилсан байна.

Үлдэгдэл материал болох нэг удаагийн хаалт 10000 ширхэг, нэг удаагийн хүнсний бээлийн 8922 ширхэг, нэг удаагийн резинэн бээлий 410 ширхэг, 1 литрийн санитол 100 ш, нийт 19432 ширхэг буюу 10.9 сая төгрөгийн материалын үлдэгдлийг ОБЕГ-т буцаан хүлээлгэн өгсөн байна.

2.4. Аймгийн Сонгуулийн хороо хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороодод зардлыг санхүүжүүлэхдээ тухай бүр аргачлал, зөвлөмжийг хүргүүлж хяналт тавьж ажилласан байна.




**ДОРНОД АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**
21000. Чойбалсан, Дорнод аймаг,
Утас/ факс: 7058-4681

2020.08.17 № 03
танай _____-ны № _____-т

Г ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Сонгуулийн зардалд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

ДАРГА  П.БАТ-ӨЛЗИЙ

Б. Болортуул:
Аудитын тайланг үзсэн
хяналт, т.а. он мунд асар
батлагдсан төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан асуудал гарсан
зарцуулсан зарцуулсан ашигтай.

010620043

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна.
2. Сонгуулийн хороодод төсвийг аргачлалын дагуу тооцон хуваарилсан байна.
3. Батлагдсан төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан асуудал гарсан байна.
4. Аймаг, сумдын Сонгуулийн хороо төсвийн гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.
5. Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.
6. Аймгийн Сонгуулийн хороо хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.



ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг
Дорнод аймгийн Сонгуулийн хорооны дарга П.Бат-Өлзийд зөвлөж байна.

1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай,
хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 08 сарын 17 өдөр

Дугвар 19

Чойбалсан хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор С.Оюунгэрэл, аймгийн Сонгуулийн хорооны дарга П.Бат-Өлзий нарт хүргүүлсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Дэлгэрмаад даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

110419126



Дорнод аймаг Хэрлэн сум, 7-р баг, аймгийн Засаг даргын
Тамгын газрын 2-р байр, 1, 2 давхарт
Утас: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-мэйл: dornod@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn